

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-25

<i>1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7-23
<i>2.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	23-25

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
05 дугаар сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Ж.Батсуурь;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Ж.Баясгалан, П.Мөнхтулга;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Чойжилсүрэн;
Тасалсан: Ж.Ганбаатар, П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Ч.Номин, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Г.Тэмүүлэн.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт орсон “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Амарбаясгалан, А.Батпүрэв, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Р.Шинэгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин, Д.Үүрийнтуяа, Н.Алтанхуяг, Ө.Шижир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Пунсалмаа, Да.Цогтбаатар, А.Ганбаатар нар үг хэлэв.

Н.Наранбаатар: Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаа, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газар /ТӨҮГ/-ын захирал Д.Оюунболд, мөн үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга Э.Балт, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын ерөнхий инженер З.Энх-Оргил, мөн үйлдвэрийн газрын Барилга байгууламжийн зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Нэргүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн нэрийн “хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж өөрчлөн, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “хугацаандаа” гэсний өмнө “эсхүл бусад шалтгаанаар” гэж нэмж, “тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “2026 оны 07 сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Энэ тогтоолын 1.1 дэх заалтад заасан тайланд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх, эсхүл хууль зүйн тодорхой үндэслэлтэйгээр цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх эсэх саналаа энэ тогтоолын 1.1-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.4, 1.5 дахь дэд заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Улсын Их Хурлаар жилийн төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн бүх шатанд Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т заасан цахим систем дэх мэдээллээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг Улсын Их Хурлын гишүүд нээлттэй харах боломжийг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2, 3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 4 дэх заалтын дугаарыг “3” гэж өөрчлөх.

“2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 9

Бүгд: 17

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 2, 3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 4 дэх заалтын дугаарыг “3” гэж өөрчлөх.

“2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Н.Наранбаатар/-нд даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “зогссон” гэсний дараа “, анхны төсөвт өртөг нь 50-аас дээш хувиар нэмэгдсэн,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 9
Бүгд: 17
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “төсвийн хуульд тусгаж” гэсний өмнө хэдэн оноос хойших төслүүд хамааралтай байх талаар эхэлсэн хугацааны хязгаарлалт тавих гэсэн саналаа татаж авав.

Найруулгын санал

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “хуульд тусгаж” гэснийг “хуулиар баталж” гэж, “анх батлагдсан” гэснийг “анхны” гэж, “буй ачаалал, дарамт” гэснийг “байгаа нөлөөлөл” гэж, “бүрээр тус бүр үнэлж” гэснийг “нэг бүрээр судалж” гэж тус тус өөрчилж, мөн дэд заалтын “талаар судалж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 19 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 57 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 5 сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Пүрэвжавын Сайнзориг, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Ринчиндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар, Жигжидийн Батжаргал, Гомбын Ганбаатар, Батжаргалын Заяабал, Нанзаддын Наранбаатар, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралд та хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 2.Байнгын хорооны тогтоолын төсөл шинжээч томилох тухай. 3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа нарын 13 гишүүн 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Хэлэлцэх асуудлын дараалалд байгаа Нийслэлийн, яг юуг нь юу гэж бичлээ, хэдэд нь билээ 4-д нь билүү, 2 дахь асуудал дээр байгаа Шинжээч томилох асуудал зарим газруудаасаа санал хүлээж байгаа учраас энэ асуудлыг өнөөдрийн хуралдаанаас хойшлуулж өгөхийг хүсэж байна.

Н.Наранбаатар: Энхтүвшин, тийм байна уу. Энхтүвшин гишүүний гаргасан 2 дахь асуудал буюу Байнгын хорооны тогтоолын төсөл Шинжээч томилох гэдэг асуудлыг хойшлуулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. Болохгүй. Мөнхсоёл гишүүнээ байж байгаарай одоохон санал хураалт явуулаадахъя, гялс саналаа хураачихъя. Батболд гишүүн хойшлуулчихъя, одоо бэлэн биш юм чинь түүхий юм юугаа хэлэлцэх юм. Санал хураалтад бэлтгээрэй гишүүд. Батболд гишүүн ороогүй байна санал хураалтад. Ингээд 8 хүн орсон байна. Ганхуяг дарга ирж байна. 8 л болчихоод байна, 9 болчихлоо. Төхөөрөмж. 10 гишүүн санал хураалтад бэлтгэсэн байна.

Энхтүвшин гишүүний гаргасан саналыг горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 56,3 хувиар дэмжигдсэн тул 2

дахь асуудал буюу Байнгын хорооны тогтоолын төсөл Шинжээч томилох тухай асуудал хойшлогдлоо. Өөр санал байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026.03.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нэг дэх асуудал. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүний өргөн мэдүүлсэн ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэж, хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнарэн Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Дармаагийн Амарбаясгалан Ардчилсан нам /АН/-ын бүлгийн зөвлөх, Аюушсүрэнгийн Батпүрэв АН-ын бүлгийн зөвлөх, Рэгзэнгийн Шинэгэрэл Улсын Их Хурлын гишүүний зөвлөх. Татварын ерөнхий газрын дарга хаана байна вэ Цогтнарэн? Дуудаарай, яагаад ирэхгүй байна.

Төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баярмаа танилцуулна. Баярмаа гишүүнийг микрофонд урьж байна, 5 номер.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрьё. Тэгээд ХХОАТ-ыг бууруулж, 1 хувь болгох энэ 100 мянган иргэний гарын үсэг бүхий саналыг хууль болгоод, 32 Улсын Их Хурлын гишүүн гарын үсэг зурж, хамтран санаачлагчаар өргөн барьсан байгаа. Танилцуулгыг хийе.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.4.1-д заасны дагуу нийтийн өргөдлийн цахим системд иргэн Рэгзэнгийн Шинэгэрэлийн байршуулсан ХХОАТ-ын хэмжээг нэг хувь болгон бууруулах өргөдлийг 100187 иргэн ердөө зургаахан хоногийн дотор дэмжсэн. Дэмжигчдийн 84 орчим буюу 84 мянган хүн нь 18-аас 40 насны залуус, 57 хувь нь эмэгтэйчүүд байсан. Энэ үзүүлэлт татвар төлөгчдөд татварын хувь хэмжээг бууруулах нь ус агаар мэт хэрэгтэйг харуулж байна.

Үүнээс гадна Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050, улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, Засгийн газар /ЗГ/-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өрхийн орлогыг нэмэгдүүлэх, дундаж давхаргыг тэлэх, иргэдийн татварын ачааллыг бууруулах зэрэг зорилтууд тус тус туссан нь энэхүү хуулийн төслийн эрх зүйн үндэс юм. Татварын бодлогын хувьд Монгол Улс өнөөг хүртэл иргэдийн орлого хувийн хэвшлийн өсөлтийг дэмжихээс илүүтэйгээр татвар хуримтлуулах замаар төсвийн зарлагаа санхүүжүүлэх чиглэлд давамгайлж иржээ. Үүний үр дүнд сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын төсвийн орлого 6 их наяд төгрөгөөс 33,5 их наяд төгрөг болж, 5,5 дахин өссөн байна. Гэтэл энэ хугацаанд иргэдийн голч цалин ердөө 3,2 дахин өсжээ. Өөрөөр өөрөөр хэлбэл төрийн орлого иргэдийн орлогоос илүү хурдтай нэмэгджээ.

2018 онд төрийн нийт зарлага дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ий 30 хүрэхгүй хувьтай тэнцэж байсан бол өнөөдөр 35 хувиас давсан байгаа нь төрийн

бүтэц данхайж, төрийн оролцоо эдийн засагт улам их нэмэгдсэнийг илтгэж байна. Өнөөдөр Монгол Улсад ХХОАТ-ын орлогын 82 орчим хувь нь цалингаас суутгаж авч буй татвараас бүрдэж байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 930 мянган ажилтны 53 хувь нь 2 саяас 2 сая төгрөгөөс доош цалинтай байна. Мөн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж /ААН/-үүдийн 86,8 хувь нь 1-ээс 9 ажилтантай жижиг бизнесүүд бөгөөд нийт 500 гаруй иргэний дундаж цалин нь 1,7 сая төгрөг байна. 2026 оны эхний 4 сарын байдлаар 2 сая 120 мянган иргэн 13,34 их наяд төгрөгийн хэрэглээний, 190404 иргэн 1,12 их наядын хугацаа хэтэрсэн болон чанаргүй, 601 мянга иргэн 6,38 их наядын цалингийн, үүнээс 104 мянган иргэн 883 тэрбумын хугацаа хэтэрсэн болон чанаргүй цалингийн зээлийн тус тус үлдэгдэлтэй байна.

Мөн өргөн хэрэглээний барааны үнэ, нийслэлийн татварууд, авто тээврийн татвар, зам ашигласны төлбөр, цахилгаан, дулаан, ус зэрэг суурь үйлчилгээний тарифууд үе шаттайгаар нэмэгдэж, иргэдийн бодит орлогыг улам бууруулж байна. Өнөөдөр хөдөлмөр эрхэлж хамгийн шударгаар татвар төлж буй цалинтай иргэд дундаж давхаргын жишгээр хуримтлал үүсгэж, хөрөнгөжиж чадахгүй, эсрэгээрээ инфляц, зээлийн дарамт, татвар, нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/-ийн ачаалалд хамгийн их өртөж, өрнөөс өрний хооронд амьдарч байна.

Хуулийн төсөл нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан татварын хэмжээг нэг хувь болгон бууруулах агуулгатай. Энэ өөрчлөлтөөр иргэдийн гар дээр үлдэх бодит орлого нэмэгдэнэ, худалдан авах чадвар сайжирна, хөдөлмөр эрхлэх идэвх нэмэгдэнэ, цалингаа нуух бэлэн мөнгөөр тооцоо хийх зэрэг сүүдрийн эдийн засаг хумигдана, хувиараа бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх сонирхол нэмэгдэнэ, дундаж давхаргыг бодлогоор дэмжих нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Мөн татварын таатай орчин нь жижиг, дунд бизнес, үйлчилгээний салбарын орлогыг дэмжсэнээр татварын бааз суурь нэмэгдэж, эдийн засаг дахь цусны эргэлт сайжрах ач холбогдолтой юм.

Эрхэм гишүүд ээ, жижиг өөрчлөлтүүд эдийн засгийг өөрчилж чадсангүй. Харин ХХОАТ-ыг нэг хувь болгож бууруулах төсөл иргэдийн орлогыг хамгаалах, дундаж давхаргаа дэмжих, эдийн засгаа ил болгох бодит реформ юм. Мөн энэ зөвхөн татварын хувь хэмжээ бууруулах асуудал биш. Энэ бол төр өөрийнхөө үрэлгэн бүтэц, зардлаа танаж, төрийн шинэчлэл хийх бодит шаардлага, бодит боломж юм. Хамгийн чухал нь зөрөө багахан мөнгийг төрд хураалгаж зарцуулахаас илүүтэйгээр өөрөө зарцуулах нь хамгийн ухаалаг үр ашигтай зарцуулалт болно. Иймд ХХОАТ-ыг нэг хувь болгож бууруулах энэхүү 100 мянга гаруй иргэдийн санал болгосон хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүд дэмжинэ гэдэгт итгэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Баярмаа гишүүнд баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Тусдаа. Одоо асуулт асуух гишүүд нэрсээ өгнө. Энхтүвшин гишүүнээр тасаллаа, дараалалд нь оруулаарай. Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Энэ цаг үеэ олсон ийм хуулийн төсөл орж ирж байгаа. Тэгээд сүүлийн үед энэ бензин шатахууны үнэ ханш маш их нэмэгдсэн, үүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн маш их нэмэгдэж байна. Хувь хүн дээр маш их ачаалал очиж байна. Тэр ч үүднээсээ орлогын албан татварыг бууруулах үнэхээр хэрэгцээ шаардлага ард иргэд дээр үүссэн. Тэр ч үүднээсээ

өнөөдөр энэ санал асуулга, энэ хүмүүсээс авсан санал дээр иргэд маш их дэмжсэн байна л даа. Хөдөө сумд айл өрхүүдэд очиход яг энэ асуудлыг ярьдаг. Бид ингээд татвар төлөөд л байдаг, төлөөд л байдаг, бидэн дээр энэ төрийн ямар бодлого ярьж байгаа юм бэ? Үүний цаана хулгай, энэ төрд байгаа улсууд тэдэн хэдэн их наядаар нь ингээд идчихсэн, тэгсэн уусан, идсэн гээд ийм л хулгай ярьж байна та нар.

Ер нь энэ төр яг юу хийгээд байгаа юм бэ? Энэ төсөв мөнгө чинь хэдий хэмжээгээр нэмэгдсэн, тийм хэмжээгээр л хулгай хийдэг юм байна. Тэрнээс энэ сумд, энэ айлд, энэ хөдөөд, энэ манай хаалгаар ямар ч өсөлт орж ирсэнгүй. Харин энэ татвар л ингээд л байнгын байж байдаг, байнгын л татвар төлж байдаг ийм асуудлыг ярьж байдаг. Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжиж байна. Энэ хуулийн төсөл хэрэгжсэнээр айл өрхүүд дээр хэдий хэмжээний дэмжлэг очих вэ, айл өрхүүд маань энэ дарамтаас яаж, ямар байдлаар чөлөөлөгдөх вэ гэдэг дээр тодорхой хариулт хэлж өгөөч гэсэн ийм асуулт байна?

Н.Наранбаатар: 5 номер.

Ж.Баярмаа: Энэ 9 хувийг нь хөнгөлснөөр ер нь иргэдэд 2,7 орчим их наяд төгрөг үлдэх юм. Энэ яах вэ нөгөө талдаа төсвийн орлого төдий чинээ буурна гэж байгаа боловч энэ 2,7 их наяд төгрөг элсэнд асгасан ус шиг огт алга болохгүй, гол руу шидсэн чулуу шиг огт алга болохгүй. Эсрэгээрээ энэ 2,7 их наяд нь өөрөө төсөв рүү орвол яадаг билээ жинхэнэ энэ төсвийн зарцуулалт хаашаа юунд яваад байгаа нь мэдэгдэхгүй ёстой элсэнд ус асгасантай адилхан болдог. Тэгэхээр энэ 2,7 их наяд төгрөг иргэдэд үлдсэнээр энэ иргэд чинь энийгээ яах вэ сумын иргэд гэлээ гэхэд нөгөө дэлгүүртээ орж худалдаа бараагаа хийх нь. Одоо үсээ ч засуулж чадахаа больсон гэж байна шүү дээ. Үсчиндээ орж жоохон ч гэсэн үсээ засуулах нь. Улмаар тэр үсчний, тэр дэлгүүрийн, 8 нэрийн дэлгүүрүүдийн яах вэ орлого нэмэгдэх нь. Орлого нэмэгдэхийн хэрээр тэр төлөх татвар нь түүгээрээ яах вэ бас нэмэгдэнэ.

Энэ 2,7 их наядыг иргэд өөрснөө дураараа захиран зарцуулна гэсэн үг шүү дээ. Төрд өгч захиран зарцуулуулахын оронд өөрснөө зарцуулна гэдэг чинь хамаагүй илүү үр ашигтай, илүү бодитой, илүү яг хувь хүний амьдралд нэмэр болохуйц ийм л зарцуулалт болно. Тэгээд мэдээж хэрэглээний, хэрэглэж байна шүү дээ энэ мөнгийг чинь ерөөсөө аваад алга болгочихгүй, хэрэглэнэ гэдэг чинь хэрэглээний татвар нэмэгдэнэ. Нөгөө НӨАТ-ын татвар түүгээрээ, ингээд нөгөө татварын бааз суурь нэмэгдэнэ. Тэгээд энэ агуулгаараа эдийн засаг дахь цусны эргэлт сайжирч, эдийн засагт ямар нэгэн хортой юм уу, сөрөг үр дагавар ерөөсөө гарахгүй. Тэгээд энэ иргэддээ итгэх хэрэгтэй байгаа юм. 9 хувийг нь хурааж аваад би чиний өмнөөс зарцуулъя гэдэг чинь хэр ухаалаг зарцуулалт болох вэ. Иргэн өөрөө өөрийнхөө хөдөлмөрлөж олсон тэр 9 хувиа авч үлдээд, 2 сая төгрөг байлаа гэхэд 180 мянган төгрөг л авч үлдэх тухай яригдаад байгаа юм. Тэгэхээр энэ 180 мянган төгрөгийн зарцуулалт илүү ухаалаг, илүү үр ашигтай, яг тухайн гэр бүлд маш их тийм ач холбогдолтой, үр ашигтай, хэрэгтэй ийм л зарцуулалт болох юм.

Н.Наранбаатар: Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр d.petition дээр болохоороо бид 100 мянган иргэний гарын үсэг цугласан тохиолдолд тухайн хуулийг боловсруулан ажиллаж явна гээд ардчилсан нийгэмд байх ёстой маш том чухал функцийг оруулж өгсөн байгаа юм. Тэгээд энэний дагуу ХХОАТ-ыг нэг хувь болгохыг иргэд маань дэмжсэн. Мөн НӨАТ-ын буцаан олголтыг 5 хувь болгохыг ч гэсэн иргэд

маань дэмжсэн байгаа. Гэхдээ энэ дээр нэг зүйлийг би энэ ажлын хэсгийнхнээс асуумаар байгаа юм. Яг энэ d.petition дээр 100 мянган иргэн маань дэмжээд ороод ирэхэд ЗГ маань энэ хуулийг нь бид санаачилна гээд явдаг. Эргэн сануулахад 2025 оны 8 сард энэ Занданшатар Ерөнхий сайд байхдаа НӨАТ-ын буцаан олголтыг 2 хувиас 5 хувь болгоно, энийг ЗГ өргөн барина гээд Сангийн яамтайгаа орж ирээд энэ хуулиа хамгаалаад, тэгээд гишүүд ч гэсэн энэ нь маш зөв юм. Энэ өөрөө яг иргэд дээр буцаан олголт нь очих учраас энэ хуулийг бид бүхэн дэмжих ёстой юм гээд УИХ-аар Улсын Их Хурлын гишүүд нь дэмжээд баталсан байсан.

Тэгсэн чинь өнөөдөр буцаад Эдийн засгийн байнгын хороогоор орж ирээд, яг Монгол Ардын нам /МАН/-ын томилсон сайд нь ахиад нөгөө Сангийн яамны хүмүүс нь яг адилхан хүмүүс орж ирээд буцаагаад боломжгүй шүү дээ, одоо бид тэрийг хэрэгжүүлэх боломжгүй энэ хуулиа хүчингүй болгоё гээд ороод ирж байгаа юм. Энэ нь юу болж байна гэхээр иргэдийн уур бухимдлыг 100 мянган хүний гарын үсэг цугласан гэдгээр нь бид ЗГ шийднэ гээд хууль өргөн бариад, батлуулаад, хэрэгжүүлэхгүйгээр буцаагаад дараагийн сайд нь орж ирээд хүчингүй болгуулчихдаг нэг ийм юм харагдаад байна.

ХХОАТ-ыг нэг хувь болгоно гээд иргэн Шинэгэрэл санаачлаад, Баярмаа гишүүн нарын 30 хэдэн гишүүн бас энийг өргөн бариад явж байхад ЗГ ахиад ХХОАТ-ыг нэг хувь багасгах төсөл бас өргөн барьчихсан явж байгаа хамт. Тэгэхээр ЗГ яг гишүүдэд хэлж байгаа зүйл нь гишүүд энэ хууль явахгүй, тэгэхээр ЗГ-ынхаа хуулийг явуулъя гэж байгаа юм. Гэтэл өнөөдөр НӨАТ-ын буцаан авалтыг 5 хувиасаа буцаад ухарч байгаа шиг, ЗГ ХХОАТ дээр хийж байгаа бодлогоосоо ухрах байдал гарч ирэх ийм сөрөг зүйл ажиглагдаад байна л даа. Тэгэхээр энэ дээр Баярмаа гишүүний байр суурийг энэ дээр яг сонсмоор байгаад байна. Тэгэхээр ер нь УИХ дээр баталж байгаа хууль тогтоомжууд маань өөрөө буцаад холбогдох яамнууд нь судалгаа тооцооллоо хийгээд танилцуулж байдаг. Сангийн яам бол маш хариуцлагагүй ажиллаж байгаа гэдэг нь харагдаж байгаа. Сангийн яамны мэргэжилтнүүд тухайн үед 6 сарын өмнө энэ байх боломжтой юм, бид бүхэн бүх тооцооллуудаа хийсэн, төсөв маань энэ хэмжээгээр хумигдаад ингээд явах боломжтой гэж танилцуулж байсан бол өнөөдөр буцаад явчихсан гэх мэтчилэн байгаад байна.

Тэгэхээр ер нь бид бүхэн маань ингээд нэг хиймлээр Занданшатар Ерөнхий сайд тэр үедээ 5 хувь болголоо гээд нэг фэйсбүүк дээр like аваад дуусаж байсан, буцаагаад тэрийг нь байхгүй болгочихдог, хариуцлага гэдэг зүйл байдаггүй нэг ийм зовлон үүсчхээд байна. Тэгэхээр энийг цааш нь үргэлжлүүлж болохгүй. Тэр утгаараа энэ ХХОАТ нэг хувь болохыг бид бүхэн зайлшгүй дэмжиж явуулах шаардлагатай байна.

Н.Наранбаатар: 5 номер микрофон нээе.

Ж.Баярмаа: Тэгэхээр ерөөсөө энэ манай ЗГ 1 дүгээрт хэдэн ч удаа солигдов. Солигдохынхоо хэрээр энэ бодлогууд нь маш ихээр солигдож байна. Энэ төрд нөгөө жинхэнэ бидний байнгын ярьдаг залгамж чанар байхгүй болсон байна. Засаг солигдож болно, гэхдээ тэр залгамж чанар нь иргэдийнхээ эрх ашгийн төлөө ажиллаж байх ёстой, ажиллаж байх ёстой. Занданшатар Ерөнхий сайд маш их рийл хийгээд, чухамхүү ерөөсөө бүр маш том гавьяа байгуулна гээд төдий чинээ иргэдийн хүлээлтийг бий болгочихсон байсан. Иргэд хийх юмаа олж ядаад л чихээ сортойлгоод сууж байгаа юм биш. Үнэндээ энэ зургаахан өдрийн дотор 100 мянган хүн гарын үсэг зурна гэдэг чинь, дахиад цаана нь 25 хоногийн дотор ингээд 100

мянгаар төсөөлбөл бараг 500 мянган иргэн гарын үсэг зурахад бэлэн байсан байгаа юм. Тэгээд 30 хоногийн дотор энэ боломжийг нь олгохгүйгээр ингээд энэ манай энэ D парламентын нэг юу байна л даа, технологийн нэг зүйл нь хаачихдаг юм байна лээ. 100 мянга хүрсэн гээд ерөөсөө зургаахан өдрийн дотор хаачихсан.

Тэгээд энэ юуг илтгэж байна гэвэл ерөөсөө л энэ НӨАТ-ын буцаан олголтын 5 хувь ч гэсэн ямар чухал байсныг харуулж байна. ХХОАТ-ыг нэг хувь болгож ингэж жигдэлж бууруулахын чухлыг харуулж байна. Бүхэлдээ энэ иргэд ерөөсөө бараг амьсгаа авч чадахгүй хэмжээнд очсоны л илрэл шүү дээ. Ийм хурдан хугацаанд ийм олон иргэд дэмжинэ гэдэг чинь. Тэгэхээр бодлогын чанар, залгамж халаа нь байхгүй байна. Тэгээд тухайн үедээ төсөвт ирэх дарамт юу вэ гээд л мэдээж хүн болгон санаа зовж байхад юу гэж байсан бэ гэвэл ямар ч асуудалгүй, Монгол Улс нэгдсэн төсөвтэй. Тэгээд энэ чинь нэг л төсөвтэй юм чинь нэг савнаасаа аваад ингээд өгөх, өгөхгүй 2 чинь бараг агаар нэг л болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйл байхгүй, асуудалгүй гэж байсан боловч өнөөдрийн ЗГ болохоор ингээд боломжгүй болгосон л явж байна л даа.

Тэгэхээр энэ дээр нэг их болохгүй зүйл байхгүй гэж бодож байна. Засгаас орж ирсэн ХХОАТ-ыг 792 мянгад чөлөөлнө гээд. Тэгээд энэ чинь бас л тодорхой хэмжээнд төсөвт цоорхой үүсэх нь. Энэ цоорхойг яаж нөхөх вэ гээд бодвол надаас асуух байх. Засаг өөрөө юу гэж хариулж байгаа гэвэл Монгол Улс нэгдсэн төсөвтэй, тэгээд энэ нэгдсэн төсвөөрөө тэр дутсан зөрөөг нь өгнө, асуудал байхгүй гээд. Тэгээд ингээд явж байгаа шигээ тэр юуны НӨАТ-ын буцаан олголтыг 5 хувь болгосон үед дахиад л тэр улсын нэгдсэн төсвөөсөө зөрөө мөнгийг нь олгох л байсан.

Нөгөө талдаа тэр зардлаа танах гэдэг тал дээр ерөөсөө толгойгоо ажиллуулахгүй байгаа юм ерөөсөө. Тэгээд тэрэн дээрээ илүү түлхүү энэ тооцоо судалгаагаа хийгээд, юуг, яаж хасвал төдий чинээ иргэдийн дарамтаас багасгах вэ гэдгээ л уг нь бодож суух ёстой юм л даа. Нэмэх биш.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Өмнө би чуулган дээр энэ нөгөө өргөн барьсан Татварын хуулиудтай холбоотой асууж байсан. Татварын ерөнхий хуулийн 4.2 дээр татварын хөнгөлөх, чөлөөлөх хувь хэмжээ болон суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гээд ийм заалт Татварын ерөнхий хуулийн 4.2 дээр тодорхой заачихсан байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл яг саяын ярьдаг шиг бид энэ татварыг зүгээр жилийн дундуур ингээд бууруулна гэдэг асуудал яривал энэ нь ингээд үр дүнгүй ийм ажил болох гээд байгаа учраас зардалтайгаа уялдуулах үүднээс төсвийн ярих, энэ төсөвтэйгөө уялдуулж энэ татварын хуулиудыг өөрчлөлтийн асуудлуудыг ярьдаг ийм Монгол Улс хуультай энэ татварын хуультай.

Тэгэхээр ингээд жилийн дундуур нь татварын хуулиуд оруулж ирээд, энэ нь өөрөө нөгөө зардалтайгаа уялдахгүй болохоор хий хоосон ийм улс төрийн ярианы сэдэв болох магадлалтай болчихоод байна л даа. Тэгэхээр энэ талаар энэ 4.2-ыг юу гэж харж байгаа юм бэ гэдгийг хууль санаачлагчаас асууя 1 дүгээрт?

2 дугаарт 2,7 их наядыг жишээлбэл иргэдэд энэ мөнгийг үлдээнэ гэж байна. Энийг Монгол Улсын дундаж цалин сүүлийн байдлаар 2,8 сая төгрөг байх шиг байна

нэрлэсэн цалин. Тэгэхээр энэ дундаж цалингаас дээш орлоготой нь энэ 2,7-гийн хэдэн хувийг нь авч үлдэх юм, доош нь хэдэн хувийг нь үлдэх юм гэдэг ийм нэг тоо байвал хэлж өгөөч?

3 дугаарт нь энэ татвар маань яах вэ үлдэж байгаа, иргэдэд үлдэж байгаа ч гэсэн нөгөө талаас энэ хүн амын орлогын албан татвар чинь сум, дүүргийн төсвийг бүрдүүлдэг гол татвар байдаг. Тэгэхээр энэ сум, дүүргүүдийн татварын энэ орлого 2,7 их наядаар буурч байгааг нь яаж нөхөх гэж байгаа вэ? Энэ Татварын ерөнхий газар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга нараас асууя? Дээр нь энэ Сангийн яам болон Татварын ерөнхий газрын даргаас яг энэ хуулийг хэрэгжүүлэх бидэнд ийм боломж байгаа юм уу, орон зай байгаа юм уу гэдэг талаар мэдээлэл өгөөч? Баярлалаа.

Н.Наранбаатар: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Татварын ерөнхий хуулийн 4.2-т заасан энэ заалтыг Энхтүвшин гишүүн асууж байна. Тэгээд энэ 2019 онд орсон өөрчлөлт юм билээ. Энэ 19 оноос хойш аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/-ын хуулийг 2020 онд, 2022 онд, 2023 онд, дахиад 2023 оны 7 сард, 2024 оны 4 сард, 2024 оны 5 сард, 2025 оны дахиад 5 сарын 30-нд гээд ингээд бараг хэд вэ 8 удаа өөрчлөлт оруулсан байна, 8 удаа энэ хууль батлагдсанаас хойш. Тэгэхээр энэ Үндсэн хуулиар олгосон Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах тэр эрхэд энэ заалт халдахгүй байгаа юм, халдахгүй байгаа юм.

Нөгөөтээгүүр ингээд энэ заалт хэрэгжихгүй байгааг нь би сая энэ маш олон хуулиуд, хуулийн заалтууд өөрчлөгдсөнөөр нотолчихлоо. Тэгэхээр магадгүй энийгээ нэг тийшээ болгох нь зөв байж магад. Ингээд нэг ийм хуурай заалт оруулчихдаг, энийгээ засаг нь өөрөө хэрэгжүүлдэггүй, засаг нь. Тэгэхээр гишүүд тэр тусмаа өөрсдийнхөө хууль өргөн барих энэ эрхээ эдэлнэ. Ялангуяа энэ иргэдийн хүсэл, хэрэгцээ шаардлага дохио байна шүү дээ. 100 мянган иргэн энийг хүсээд хүлээгээд сууж байна. Тэгэхээр энийг Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийнхаа үүргийн дагуу боловсруулахад ямар нэгэн саад байхгүй, засаг хүртэл боловсруулаад оруулчихсан явж байгаа.

2-т дундаж цалин, одоо ХХОАТ-ын 82 хувийг нь энэ цалингаас бий болгож байгаа юм 82 хувийг нь. Тэгээд энэ цалин аваад татвар төлж байгаа иргэдийн 500 гаруй мянган иргэн нь 1,7 саяын дундаж цалинтай гэж байгаа юм. Энэнээс дээшээ буюу бодвол 2 дугаар, 3 дугаар шатлалыг асууж байна. 2, 3 дугаар шатлал буюу жилийн 120 саяас дээш цалинтай иргэд Монгол Улсын хэмжээгээр 6350 байна давхардсан тоогоор шүү, давхардсан тоогоор. 120-оос 180-ын хооронд 3150, 180-аас дээш 3200 орчим. Ингээд ерөөсөө Монгол Улсын хэмжээнд уртаашаа 10 саяас дээш төгрөгийн цалин авч байгаа хүн дахиад хэлэхэд давхардсан тоогоор 6 мянга гаруй л байна. Тэгэхээр яах вэ энэ улсуудын татварыг их байлгах хэрэгтэй, энэ баячуулаас их татвар авах ёстой гэдэг ийм зүйлийг ярьдаг л даа.

Тэгэхээр энэ нэг давхардсан тоогоор 6 мянган иргэдээс 10 хувийн татвар юм уу, 15 хувийн татвар авч хорлох юм уу яах юм мэдэхгүй. Тэгэх нь зүйтэй юм уу, эсхүл нийт энэ цалин авч, ажил хөдөлмөр эрхэлж байгаа энэ сая орчим иргэдийнхээ төлөх татварын ачааллаас нь бууруулах юм уу гэдэг энэ 2 зүйлийн энэ огтлолцол дээр л байгаа юм. Тэр төсвийн орлого тийм ээ. Тэгээд энэ 6 мянган хүн дотор чинь нөгөө том, том компаниудын СЕО-ууд байх шиг байгаа юм, инженерүүд байх шиг байгаа

юм, гол л технократуудын л 6-хан мянга, 3 мянга ч юм уу бараг давхардсан тоогоор хүмүүсийн л тийм 10-аас дээш хувийн татвар төлдөг ийм маш бага орон зайтай юм билээ.

Нэг л зүйлийг хэлэхэд орон нутгийн төсөв тасарна гэж ярьж байгаа. Дэлхийн банкны судалгаа байгаа. Дэлхийн банкны судалгаа юу гэж хэлсэн байна гэвэл орон нутгийн төсөв бүх төрлийн татварын буцаалт, татвар зэргээс улсын төсвөөс буцааж олгож байгаа энэ дүн орон нутгийн нийт төсвийн 80 хувийг нь бүрдүүлж байна гэж байгаа юм 80 хувь. Өөрөөр хэлбэл тэртээ тэргүй улсын төсвөөс.../минут дуусав/

Н.Наранбаатар: Татварын ерөнхий газар хариулна. 8 номер уу? 8 номерын микрофон.

Ч.Чимидсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Татварын, Сангийн яам Татварын бодлогын газар Чимидсүрэн. ХХОАТ-ын хувийг нэг хувь болгохтой холбоотой нэг хэд хэдэн анхаарах зүйлүүд байгаа. Тэгэхээр бусад орнуудад дэлхий нийтэд 170 гаруй оронд энэ ХХОАТ-ын дундаж хувь 20 гаран, бараг 30-аад хувьтай байгаа юм. Манайх хувь хэмжээний хувьд 10 дотор ордог ийм бага татвартай орон. Тэгээд шаталсан татвартай ийм орон байгаа. Ер нь 1990-ээд оноос хойш шинэ үеийн Татварын алба үүсгэн байгуулагдсанаас хойш энэ ХХОАТ шаталсан татвартай байсан, дээд тал нь 45 хувь хүртэлдээ цалингаас нь авдаг ийм шатлалтай улс байсан манай орон бол. Ингэж байгаад 22 оноос авхуулаад бид энэ шаталсан татварын системээ сэргээж оруулж ирсэн. Тэгээд энэ дээр 10 саяас дээшид нь 10 хувь, 15-аас 10.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээе.

Ч.Чимидсүрэн: Ийм шатлан 10, 15, 20 хувиараа тооцдог болсон. Үүн дээр Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/-д тодорхой иргэд нэг ийм шаталсан татвартай биш, нэг тогтмол хувьтай байх ёстой гэсэн асуудал гаргаад, тэгээд Цэцээс дүгнэлт гаргаад, энэ шаталсан татвартай байх нь илүү их орлоготойгоосоо илүү их татвар аваад явах энэ бол Үндсэн хуульд нийцсэн шударга зарчим байна гэдэг дүгнэлт гарсан байдаг.

Нөгөө талаар энэ дээр нэг анхаарах ёстой зүйл нь энэ ХХОАТ-ын 14-өөс 19 дүгээр заалтуудад зөвхөн цалин хөлсний орлого биш байгаа юм. Энд бас нэг өөр бусад орлогууд яригдаж байгааг анхаарах ёстой. Иргэний бизнесийн орлого орж байгаа. Тэгээд түрээсийн орлого, хүүгийн орлого, ноогдол ашгийн орлого, үл хөдлөх, хөдлөх хөрөнгийн орлого, хувьцаа, үнэт цаас, борлуулсны орлого, урлаг, спортын бай шагнал, эд хөрөнгийн хонжворт сугалаа гээд эдгээр маань бүгдээрээ нөгөө орлогоос нь авах, эсвэл орлогоос нь түүнийг анх бий болгохтой холбоотой зардлууд нь хасагдаж байж үлдэх ашгаас нь авдаг. Мөн хувь хэмжээг нь янз бүр байдаг. Жишээ нь сугалаа.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээж хариулъя 8 номер.

Ч.Чимидсүрэн: Жишээ нь сугалаан дээр бид 40 хувиар авч байгаа юм. Тэгэхээр 10, 15, 5 хувиар ч авч байгаа татварыг бүгдийг нь ингээд нэг хувь болгоно гэдэг нэг ийм асуудал яригдаж байгааг анхаарах ёстой. ЗГ-аас саяхан өргөн барьсан Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр ХХОАТ дээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийнхээ орлогыг хамгаалах зорилгоор өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэж яригдаад байгаа энэ дүн энэ цаг үетэй таарч

байгаа учраас энэ 792 мянга хүртэлх хөдөлмөрийн хөлсийг нь 100 хувь чөлөөлчихье гэсэн ийм бодлого бариад явж байгаа. Тэгээд энэний төсвийн нөлөөлөл нь жилийн 840 тэрбум байгаа юм. Баярмаа гишүүний санаачилсан дээр 2,7 их наяд, тэгээд энэ орон нутгийн төсөв учраас дабл эффекттэй буюу ингээд 5,4 их наядын асуудал яригдах нь гэсэн үг.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Ер нь энэ татварын асуудлыг энэ төсвийн зарлагатайгаа л уялдуулахгүй бол ийм амьгүй болчих гээд байгаа учраас энэ хуулийн заалт нь өөрөө яг энийг нөхцөлдүүлж уул нь ийм төсвийн, төсөв ярихдаа татварын хувь хэмжээ өөрчлөгдөхөөр бол хөнгөлж чөлөөлөхөөр бол ярья гэдэг ийм заалт байгаа. Тэгэхээр бид хэд яах вэ өмнө нь хууль хэрэгжүүлэхгүй байсан юм чинь гээд одоо ингээд хуулиа аль, аль нь гишүүд нь ч, ЗГ нь ч гэсэн ингээд зөрчөөд байж боломгүй байгаад байгаа юм. Хэрвээ болохгүй бол энэ хуулиа өөрчилчхөөд, хуулиа дагадаг байхгүй бол хууль дээдлэх зарчим гэдэг Үндсэн хуулийн зарчим чинь гишүүд нь ч, Засгийн газар нь ч бүгдээрээ ингээд алдагдуулдаг ийм байж боломгүй байгаа юм. Тэгээд шаардлагатай бол энэ хуулийн заалтаа өөрчлөөд. Зүгээр энэ агуулгаараа бол энэ заалт нь зөв байгаа юм шиг санагдаж байна. Тэгэхээр яг бодитой хувь бууруулъя гэж байвал энэ төсөвтэйгөө уялдуулж оруулж өгдөг байгаасай. Тэгээд түрүүн цалинтай холбоотой дундаж цалинтай холбоотой, цалингаас дээш, доош энэ татварын ачаалал нь яаж ирж байгаа юм бэ гэдэг асуултыг хариултыг дараа нь өгчхөөрэй.

Н.Наранбаатар: Бичгээр, дутуу хариулт, минутдаа багтаагүй бол бичгээр өгчхөөрэй. Дараа нь Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: ХХОАТ-ын хэмжээг нэг хувь болгоод ямар үр дүн гарах вэ гэдэг дээр хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт, мэдээллийн зөрөөтэй байдал бидний дунд байгаад байх шиг байна. 2,7 орчим их наяд хөнгөлөгдөнө 9 хувь нь гэж үзэж байгаа юм байна. Тэгвэл үүнийг яг бага орлоготой иргэдэд хэд нь, дунд орлоготой иргэдэд хэд нь, өндөр орлоготой иргэдэд хэд нь очих вэ гэдгийг гаргаад өгчих. Тодорхой гаргасан судалгаа байна уу? Яагаад гэхээр ЗГ-ын хурлын тэмдэглэл дээр Монгол Улсын хувьд гэж байгаа юм ХХОАТ-ын нийт орлогын 71 хувийг хамгийн өндөр орлоготой хэсэг буюу нөгөө ХХОАТ төлж байгаа иргэдийн 13 хувь нь л бүрдүүлж байна гэж байгаа юм. Тэгэхээр чинь үлдсэн 29 хувийг татвар төлж байгаа нийт иргэдийн 87 хувь нь бүрдүүлдэг гэсэн ийм статистик энэ харагдаад байна л даа. Тэгэхээр бид нэг хувийг нь нөгөө өрхийн амьдралд хэрэгтэй, бага, дунд орлоготой иргэдэд хэрэгтэй гээд чөлөөлөх гээд байдаг. Энэ чинь нийт масс нь өөрөө өндөр орлоготой иргэдэд очиж нөлөөлөх гээд байгаа юм биш биз дээ. Энэ судалгаа яагаад зөрөөд байна вэ?

Баярмаа гишүүний хэлж байгаагаар болохоороо зэрэг үндсэндээ нийт энэ ХХОАТ-ын төлж байгаа иргэдийг аваад үзэхээр 80 хувь нь цалингаас байна гээд байгаа юм. Гэтэл Татварын ерөнхий газрын даргын мэдээлж байгаагаар болохоор энэ чинь бусад орлогууд орж ирээд байна гэж. Энэ дээр ангилчихсан ангилал, судалгаа байна уу?

Дараагийн асуудал, орон нутгийн төсөв тасарна гэдэг асуудал ярьж байгаа юм. Мөн ялгаагүй ЗГ-ын хурлын тэмдэглэл дээр орон нутгийн төсвийн орлогын бүрдэлтийн 52 хувь нь энэ ХХОАТ-аас бүрдэж байгаа гэдэг зүйлийг оруулсан байна

52 хувь нь. Тэгэхээр энийг бид 9 хувь болгож бууруулснаараа магадгүй 47, 8 хувийн орлогын эх үүсвэр дутах нь л дээ орон нутгийн. Тэгэхээр энэ өөрөө эргээд улсын төсөв дээр нөхөх орон зайг хаанаас гаргана гэж тооцож хууль санаачлагчаас энийг оруулж байгаа юм бол? Татварын ерөнхий газар мэдээлж байгаа нь болохоор сая энэ 52 хувь гэдэг ЗГ-ын юун дээр хурлын тэмдэглэл дээр байна. Гэтэл Баярмаа гишүүний тайлбарлаж байгаагаар орон нутгийн төсвийн 80 хувь нь улсын төсвөөс орон нутагт мөнгө өгч байна энэ бол төдийлөн нөлөө үзүүлэхгүй гэдэг агуулгаар тайлбарлаад байна шүү дээ. Тэгэхээр энэ мэдээллийн зөрөөтэй урсгалуудыг 1 дүгээрт нэг ойлгомжтой ижилтгэж авмаар байна. Хууль санаачлагчийн хувьд, ЗГ-ын зүгээс оруулж ирж байгаа мэдээллүүдийг датануудыг нэгтгэж, 2 талаасаа тайлбарлаж өгөөч?

Орон нутгийн төсөв, улсын төсөв аль, аль нь ялгаагүй төсвийн орлогын бүрдэлтэд тодорхой хувиар нөлөөлж байгаа учраас энэ төсвийн төсөөллийг төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа энэ цаг хугацаанд энэ 2,7 их наядыг хаана сууна гэж оруулж ирж байгаа юм бэ, хаанаас хасах танах боломжтой гэж оруулж ирж байгаа юм бэ? Мэдээж энэ төсвийн тодорхой нэг хэсгээс хасагдаж таарна. Эргээд бид татвараа бууруулна, дээрээс нь тэтгэвэр тэтгэмж нэмнэ гэвэл нөгөө дутсан эх үүсвэрээ хаанаас олох гэж байгаа юм бэ гэдэг л ийм нөхцөл.../минут дуусав/

Н.Наранбаатар: Баярмаа гишүүн хариулъя.

Ж.Баярмаа: Энэ мэдээллийн зөрөөтэй байдлыг бид мэдэхгүй. Манайх яг Үндэсний статистикийн газрын мэдээлэл дээр үндэслэж байгаа юм. Одоо надад энд байна л даа суутганаар 81 хувь, шууд бусаар нэг хувь гээд жишээлбэл энд ингээд байж байгаа байхгүй юу. Тэгэхээр яг эсрэгээрээ энэ бол арай л дэндүү том зөрөө. Тэгэхээр энийг би юу гэж тайлбарлахыг мэдэхгүй. Ямар ч байсан ингээд 973 мянган иргэн 1,9 их наяд төгрөгийн татварын цалингийн, татварын цалингийн орлогоос энэ ХХОАТ бүрдэж байна гэж байгаа юм. 96 мянган иргэний 21 тэрбум төгрөг нь шууд бус орлогоос гэж байгаа юм. Ингээд 115 мянган иргэний 79 тэрбум төгрөг болохоор үйл ажиллагааны орлогоос гэж байгаа юм. Ингээд энэ Үндэсний статистикийн газрын мэдээллийн саяын энэ миний хэлж байгаа мэдээллийг хувилаад үзэхээр цалингийн татвар нь 81 хувь, хөрөнгийн орлогын татвар нь 13 хувь, үйл ажиллагааны орлого нь 3 хувь, хөрөнгө борлуулсан, шилжүүлсэн орлого нь 0,93 хувь, шууд бус орлого нь 0,87, бусад орлого нь 0,1 гээд энэ бол Үндэсний статистикийн газрын мэдээлэл шүү 1 дүгээрт.

Энэ бол Дэлхийн банкны судалгаанаас авсан түрүүн 80 хувь гэж хэлсэн. Ерөөсөө орон нутгийн төсвийн бүрдүүлэлтийн 80 орчим хувь нь ингээд улсын төсвөөс ордог гэсэн ийм судалгаа байгаа. Энэ дээр би зүгээр нэг сумын жишээ хэлэхэд нэг сумын дундаж 2 мянга орчим иргэнтэй сумын ХХОАТ-аас бүрдэж байгаа орлого нь 200 сая байна гэнэ. Би судалгаа хийлээ. Цалингийнх нь болохоор 140 сая, бусад тэр үйл ажиллагааны орлого, малын хөлийн татвар, бууны татвар нь 60 сая. Тэгээд ингээд 200 сая байдаг юм байна. Гэтэл тэр аймгийн төсөв 2,1, сум, би сумыг ярьж байгаа шүү дээ, 2,1 тэрбум. Тэгэхээр ерөөсөө бараг 90 хувь нь улсын төсвөөс, аймгаас орж ирж байгаа нь ингээд нотлогдож байгаа байхгүй юу. Мэдээж энд нарийвчилсан яг 333 сумынх яаж гарсныг бид судалгаа авах гээд өгчихсөн байгаа. Мэдээж нөгөө орлоготой аймгууд байгаа хэдхэн аймаг байгаа шүү дээ. Тэрнээс бусад 14, 15 аймаг бол улсын татаасаар л амьдардаг, улсын татаасаар амьдардаг. Тэгэхээр энэ аймаг ингээд амьдарна гэдэг чинь яг ингээд доошоо пропорцлоод

үзвэл сумууд бүгдээрээ бараг л 90 хувиа, сумынхаа зардлын 90 хувийг улсын төсвөөс авдаг гэсэн ийм тооцоог бидний зүгээс хийж байгаа юм.

Ямар, ямар зүйлээс бид энэ мөнгийг гаргаж болох вэ гэвэл зөндөө юм байна л даа. Зөндөө л юм байна. Жишээлбэл энэ ийм дүн байгаа байхгүй юу. Зөвхөн 20-оос 26 онуудад тоног төхөөрөмжийн зардал 10,85 их наяд зургаахан жилийн дотор, бараг 11 их наядыг бид тоног төхөөрөмжид тавьдаг юм байна шүү дээ. Энэ бүүр арай л их мөнгө байгаа юм л даа. Дээрээс нь бид энэ татаас хөнгөлөлтүүд дээр реформын шинжтэй ийм өөрчлөлтүүдийг хийх ёстой, татаасуудыг. Жишээлбэл 26 онд 2,1 их наядын татаас төлөвлөсөн юм байна. Энийг нарийвчлаад харвал 588 тэрбумыг нь тэвчиж болохоор юм байна, тэвчиж болохоор ийм юм байна. Төрийн худалдан авалт эндээс жишээлбэл 300 тэрбумыг тэвчиж болохоор байна. Энэ дотор нөгөө л жил болгоны авдаг компьютер орж байна, автомашин орж байна, тавилга орж байна, программ хангамж орж байна гээд. Алдагдалтай төрийн өмчит компани /ТӨК/-уд, сая бид татварын орлогыг голцуу яриад байна. Татварын бус орлогууд буюу зардлууд явж байна. Энэ жишээлбэл алдагдалтай ТӨК-уудад.../минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмж хариулъя.

Ж.Баярмаа: ТӨК-уудад алдагдалтай ажиллаж байгаад нь маш ихээр татаас өгч байна. Эндээс жишээлбэл 150-аас 200 тэрбумыг хэмнэж болж байна. Эндээс гадна орлого талаас бидэнд юм бүрдэнэ. Жишээлбэл энэ 2,7 их наяд гээд байгаа чинь худалдан авалт хийлээ гэж бодъё, худалдан авалт хийнгүүт нөгөө НӨАТ-ын буюу хэрэглээний татвар гээд зүгээр ингээд механикаар бодоод үзэхээр 250 тэрбум, энэ иргэдэд үлдэж байгаа энэ 9 хувийн мөнгөн дүн нь нөгөө миний хэлж байгаа шиг төрд өгөөд элсэнд цацсан ус шиг алга хэзээ ч болохгүй. Энэ эргээд энэ эдийн засагт эргэлдээд явна. Тэгэхээрээ өөрөөр хэлбэл НӨАТ-ын орлого болж орж ирнэ, 250 орчим тэрбум. Төдий чинээ нөгөө ААН-үүдийн чинь орлого нэмэгдэнэ. Энэ мөнгө чинь нөгөө төр лүү ороод алга болохгүй, иргэд өөрөө дэлгүүрээс худалдан авалт хийгээд, талхаа аваад, сүүгээ аваад, хүүхдүүд нь чихэр аваад байхын хэрээр нөгөө ААН.../минут дуусав/

Н.Наранбаатар: Тодруулах уу Үүрийнтуяа гишүүн? Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Асуух асуултыг.

Н.Наранбаатар: Тэгвэл эхлээд татвар, татварынхнаас хариулчих, дараа нь тодруулъя. 8 номер.

Ч.Чимидсүрэн: Түрүүн хэлсэн энэ ХХОАТ 6 бүлэг, тэгээд цаашлаад олон төрлийн орлогуудаас хамааралтай байгаа. Цалин хөлстэй гэхэд 1 сая 22 мянган иргэн байна. Үйл ажиллагааны, бизнесийн орлоготой 144 мянган иргэн, хөрөнгийн орлоготой буюу энэ түрээсээрх, ноогдол ашиг, хүүгийн орлоготой гээд 2 сая гаруй хүн, хөрөнгө борлуулж, шилжүүлсний орлого дээр 5 мянга, шууд бус орлоготой 72 мянга гэх мэтчилэн ингээд 2,5 сая иргэний асуудал яригдсан нэлээн өргөн хүрээний энэ татварын асуудал хөндөгдөөд байгаа юм. Энийг бид саяын хэлсэн 6 бүлэг орлогын асуудлуудаар нь аваад тэр 9 хувиар тооцоод үзвэл цалин хөлс дээр гэхэд 2,2 их наядыг төсвийн цалин хөлснөөс энэ буурах жишээтэй. Үйл ажиллагааны орлогоос 36, хөрөнгийн орлогоос 206 тэрбум, хөрөнгө борлуулалт шимтгэлийн

орлого 117 тэрбум, бусад орлого 193 гэх юм бол ингээд 2,7 ийм дүнгүүдээр гарч байгаа. Яг дүүрэг, сумд буюу 330 сумдаар аваад үзвэл.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээе.

Ч.Чимидсүрэн: Тэгэхээр ХХОАТ сум, дүүргийн орлогыг бүрдүүлдэг, төсвийг бүрдүүлдэг. Тэгээд 330 сум, 9 дүүргээр аваад үзвэл доод тал нь 19 хувь, дээд тал нь 71 хувийн төсвийг нь бүрдүүлдэг ийм чухал орлого байгаа юм. Түрүүний хэлсэн, Татварын ерөнхий газраас нөгөө цалинтай холбоотой дэлгэрэнгүй нөгөө бага, дунд орлого, өндөр орлоготой тэрийг эргээгээд бичгээр өгье гэсэн шүү гишүүнээ.

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Тэгэхээр яалт ч үгүй нэг ийм судалгаатай харьцуулж байгаа юмнуудаа эргэж харахгүй бол нэг зөрөө яваад байна л даа. Орон нутгийн төсвийн 80 хувь, орон нутгийн төсвийн 80 хувь нь татаасаар очиж байна гэдэг дээр аймаг, нийслэлийн асуудал бас яригдаж байгаа байх гэж бодож байна тэр судалгаан дээр. Яг ХХОАТ чинь сум, дүүргийн орлого шүү дээ. Тэгэхээр тэрүүгээрээ нэг ялгаж үзэх нь зөв байх хууль санаачлагчийн хувьд, яг хэдэн хувь байна. Энэ тасарсан орлогыг хэрхэн нөхөх вэ гэдэг дээр анхаарахгүй бол болохгүй. Нөгөө талдаа надад тэр Татварын ерөнхий газраас би судалгааг нь авч харж байж энэ дээр дүгнэж хэлэх нь зөв болов уу л гэж бодож байна. Үнэхээр яг энэ хуулийн төсөл дээр ЗГ-ын хурлын тэмдэглэлээр өгсөн тэр тэмдэглэл дотор байгаа судалгаанаас харахаар 71 хувь нь өндөр орлоготой иргэд байна гэхээр энэ чөлөөлсөн орлого маань эргээд нөгөө дотоод эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, худалдан авалт болоод дахиад татвар өсгөх боломж нь биш болчих юм биш биз дээ? Энэ нь эргээд гадагшаа гардаг мөнгөний урсгалаа нэмээд явчих юм биш биз дээ? Өндөр орлоготой.../минут дуусав/

Н.Наранбаатар: Үүрийнтуяа гишүүн, тэндээс эхлээд юу авах уу?

Д.Үүрийнтуяа: Үгүй ээ, би дуусгачихъя.

Н.Наранбаатар: Тэгье.

Д.Үүрийнтуяа: Өндөр орлоготой иргэдийн энэ орж байгаа орлого ер нь дотоод зах зээл дээр үлдэх нь бага байдаг шүү дээ. Бага, дунд орлоготой иргэдийн нэмэлт орлого л дотоод зах зээлийг тэлж, дотооддоо худалдан авалт болж байдаг. Өндөр орлоготой хүмүүсийн орлого дандаа гадагшаа импортын худалдан авалт руу, гадагшаагаа чиглэсэн худалдан авалт руу явчихдаг. Тэгэхээр ийм байдлаар нөлөө үүсчих юм биш биз дээ гэдэг болгоомжлол байна. Тэгэхээр энэ судалгаа тооцооллуудаа нэг сайн нягталж шалгаж, ялангуяа Үндэсний статистикийн газраас гарсан энэ судалгаануудыг Татварын ерөнхий газраас гаргаж байгаа энэ тоон мэдээллүүдээ нягталж үзэх ийм зайлшгүй шаардлага байна гэж харж байна. Санал хэллээ.

Н.Наранбаатар: Санал хэлчихлээ. Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Хувь хүний орлогын албан татварыг нэг хувь болгоё гээд 9 хувиар багасгая гэж байгаа юм. Уг нь ЗГ нь байгаад, эсвэл МАН-ын бодлого гэж байдаг бол ийм асуудал орж ирэхгүй байх байсан л даа. Тэгэхээр би энийг санаачилж орж ирж байгаа Их Хурлын гишүүдийг буруутгахгүй, би бүүр энийг нь

дэмжиж явуулъя гэж бодож байна. Энэ ингээд 71 хувиар тасарна гэнэ үү, яана гэнэ вэ тэр бол илүү засгийн юуны Сангийн яамны зохицуулгын л асуудал. Нэг том тогоо байгаа түүн дотроосоо дутвал нь хаанаасаа яаж нөхөх юм гэдэг ЗГ-ын бодлого болохоос биш Баярмаа гишүүний толгойгоо гашилгадаг асуудал ерөөсөө биш.

ЗГ энэ Учрал сайд нь байна уу, Сангийн сайд энэ тэр нь байна уу? Одоо эд нарт ямар том сигнал өгч байгаа вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүд ЗГ-т итгэхгүй байна гэсэн үг. Яг энэний өмнө сая тэр нэг НӨАТ-ыг 5 болгоно гээд хууль баталсныгаа түрүүхэн орж ирээд хулхидаад алга болгочхож байна шүү дээ больё, больё гээд. Тэгэхээр иймэрхүү байдлаар Их Хурлын гишүүдийг хулхидаж байна. Ард иргэдээс баахан 100 гаруй мянган хүний саналыг авчхаад бас НӨАТ-ын буцаан олголтыг төд болгоно гээд худал хэлээд хэдэн жил боллоо. Тийм, тийм, ийм замбараагүй байдал, бодлогогүй байдал үргэлжилсээр байгаа учраас Улсын Их Хурлын гишүүд санаа нь зовоод, ард иргэдийгээ бодоод, янз бүрийн байдлаар татвар хураамжийг багасгах хуулийн төсөл санаачилж байгааг буруутгах аргагүй.

Энийг нь зөв болгох асуудал нь энэ ЗГ-ын асуудал. Ялангуяа энэ Ерөнхий сайд нь гарч ирээд хэдэн сар ч болчхов. Энэ хүн бодлогоо танилцуулах хэрэгтэй шүү дээ. Бид хүн амын бодлого татвар дээр ингэмээр байна, ААН-үүдийгээ ингэмээр байна, НӨАТ-ыгаа ингэмээр байна, ингээд нэг хэдэн төгрөг дутна тэгвэл төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй гэж үзэж байгаа ийм, ийм юмнаасаа ингэнгээ хасчихъя, ард иргэд маань энийг ойлгоорой, ингэнэ шүү. Ер нь эцсийн эцэст энэ татварын хэн гэнэ тэр Сангийн яамны? Та нар энэ хүн амын орлогын албан татварыг шаталсан болгодог чинь буруу. Энийг шаталсан байсныг нэг флат /flat/ болгосон хүн чинь би, Сангийн сайд Алтанхуяг гэдэг хүн байхдаа 2004, 2005 оны үед хийсэн юм. Яагаад гээч чи одоо өндөр орлоготой гээд 2 мянган доллар хүрэхгүй 10 сая төгрөг чинь 2 мянган доллар гаруй гээд. Үгүй ээ тэгээд ийм хүмүүсийг өндөр орлоготой гэдэг юм уу, чи дэлхийн жишиг яриад байна. Дэлхийн жишгийн цалинтай болчхоод шаталсан ийм татварыг ярь, прогрессив татварыг.

Яагаад нэг болгочхоод байгаа вэ гэхээр манай иргэд цалингаараа амьдардаг тэр нийгэм рүү бид явахын тулд нэг болгосон юм 10 хувь. Энэ бодлогоо ойлголцмоор байна. Тэгэхдээ би чамтай маргалдмааргүй байна. Ерөнхий сайд чинь, намын дарга чинь.../минут дуусав/

Н.Наранбаатар: Алтанхуяг гишүүнд нэг минут.

Н.Алтанхуяг: Асуулт асуугаад, хариулт хэлээд, хэлсэндээ хүрдэггүй юм чинь, ямар юм асуух вэ дээ. Тэгэхээр хэн гэлээ манай тэр татварынх, хэн гэнэ вэ? Чимидсүрэн. Тэгэхлээр ийм байна, чамайг буруутгах юм байхгүй л дээ, ямар чи бодлого гаргаж байгаа биш ерөнхийдөө ингээд. Тэгэхээр ийм учиртай флат болсон байхгүй юу. Флат гэдэг чинь 10 хувь. Өмнө нь ингээд 10, 15, 20 гээд ингээд. Хүний цалин наадхыг чинь шаталсан болгочихоор ААН-үүд чинь аль болохоор, иргэн ч гэсэн цалинг нь бага харагдуулахаар хичээгээд байдаг байхгүй юу. Ш... гэж хэлдэг юм даа дээр үеийнхээр бол ямар ч ялгаагүй. Тийм учраас энэ бодлого буруу, 22 онд гэж хэлсэн үү, 22 онд энэ хийсэн бодлогын буруу, одоо 4 жил буруу явж байна. Цалингийн бодлого буруу. Нөгөө талд нь дахиад засаг юун дээр анхаармаар байна вэ гэхлээр юмны үнийн өсөлтийг нь хазаарлах ямар, ямар арга хэмжээ.../минут дуусав/

Н.Наранбаатар: Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: 2025 оны байдлаар ингээд харахаар өрхийн дундаж зарлага 2,8 сая, 2 сая 850 мянга, өрхийн дундаж орлого нь 2 сая 800 байгаа байхгүй юу. Тэгээд энэ юу вэ гэхээр орлого, зарлага 2 нь зөрчихсөн байна гэсэн үг. Орлогоосоо их зарлагатай байна гэсэн үг. Тэгэхээр яадаг юм хүн зээл авна, тэгээд зээлээс зээлийн хооронд ингээд иргэд нь явчихна. Бидний уг нь энэ ганц гол энэ санаа бол уг нь энэ хэмнээд байгаа хүн амын орлогын албан татвар нэг хувь болгоод тэр иргэдэд үлдэж байгаа мөнгө чинь буцаад зах зээлд нийлүүлэгдэнэ шүү дээ, буцаад зах зээлд нийлүүлэгдэх байхгүй юу. Зах зээлд буцаад нийлүүлэгдээд явахаар энэ чинь худалдан авалтаа дэмжинэ, үйл ажиллагаагаа дэмжинэ, мөнгөн урсгалаа дэмжинэ ингээд эдийн засгийн талаас нь бид эерэг үр дүнгүүдийг нь хармаар байгаа юм.

Миний ойлгож байгаагаар энд ингээд Наранбаатар дарга байх шиг байна, Одоо Төсвийн байнгын хороонд Ардын намаас 15 хүн байдаг 3-хан хүн байгаа байхгүй юу. Дандаа АН-ынхан байгаад байгаа юм. Тэгээд засагт хамтарсан ХҮН нам нь байхгүй, ИЗНН нь байхгүй, Үндэсний эвсэл нь байхгүй, Ардын намаа дагаад бүгдээрээ гараад явчихсан. Тэгээд бид юу вэ гэхээр уг нь энэ чинь иргэдийнхээ бодит орлогыг яаж нэмэгдүүлэх вэ гэдэг ийм бодол санааг яриад байгаа юм шүү дээ. ЗГ-ын үндсэн чиг үүрэг бол яаж иргэдээ сайхан амьдруулах байна шүү дээ. Тэгэхээр яаж тамлан зовоох вэ биш байхгүй юу. Яаж бүгдийг нь хуу хамах тухай биш, яаж халаасанд нь илүү орлоготой, орлогыг нэмэгдүүлж өгөх юм бэ гэдэг ийм үндсэн бодлоготой байх ёстой юм. Уг нь гол зорилго нь энэ. Тэгээд орлого, зарлага 2 нь ингээд зөрчсөн.

Тэгээд нөгөө талаасаа ингээд харахаар нийт ААН үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд чинь бараг 90 хувь, бараг 95 мянга орчим нь 1-9 ажилтантай байгаа. Энэ юу вэ гэхээр жижиг, дунд үйлдвэрлэл дээр л бид тогтож байна гэсэн үг. Үйлчилгээ дээр бизнес эрхэлж байна гэсэн үг. Нөгөө талдаа 10 хүртэлх ажилтантай компаниудын дундаж цалин хамгийн бага байгаа, дундаж нь 1,8 сая байгаа. 200-аас дээш ажилтантай компаниудын дундаж цалин 2 дахин өндөр байгаа. Тэгээд бид нийт ААН эрхэлж байгаа ААН-н 90 хувь буюу нийт ажиллаж байгаа хүний чинь 90 хувь нь хамгийн бага цалингаар дунджаар цалин аваад байхад энэ орлогыг нь яагаад дэмжих тухай ийм бодлого байхгүй, энийг эсэргүүцээд сууцгаагаад байгаа юм. Халаасанд нь 90 мянган төгрөгийг нь илүү үлдээчихье л дээ. Улсын төсвийн зарлага болоод хэн нэг сайд, дарга нар тэр мөнгийг нь үрж байснаас хүүхдүүддээ ядаж 3 кг мах аваад өгчих л дээ энэ чинь.

Бид ингээд хэтэрхий олон жил засаглачихаараа яадаг юм мэдэхгүй амьдралаас тасраад байдаг юм уу. Юунуудаа ингээд орлого, зарлагаа бодитоор хармаар байгаа юм. Тэгээд бид яаж татварын бааз сууриа нэмэгдүүлэх юм, яаж татвар төлөгчдийг олон болгох юм гэж бодлого бодох ёстой байтал нэг үйл ажиллагаа явуулж байгаа тэр 90 мянган ААН-үүдийг яаж дампууруулж болох вэ гэдэг ийм хахир хүйтэн бодлого явуулаад байгаа байхгүй юу. Хүн амын орлогын албан татвар авна, НДШ авна, нийслэлийн худалдан авалтын татвар авна, тэгээд дээр нь янз бүрийн торгууль төлнө. Тэгээд энэ чинь иргэдэд нь халаасанд нь үлдэх мөнгө үлдэхгүй байна шүү дээ. Энийг л жоохон нэмэгдүүлье гээд байгаа юм шүү дээ уг нь. Тэгээд манайхан энэ дээр дэмжээд нэг саналаа өгчхөөч. Энэ чинь 2, 3 дахин хэлэлцүүлэг явна. Энэ олон нийтэд энэ хүрэх хэрэгтэй байгаад байгаа юм.

Н.Наранбаатар: Гишүүд танхимдаа орж ирээрэй. Төсвийн байнгын хорооны ирцэд орсон гишүүд танхимдаа орж ирээрэй. Асуулт, хариултын дараа уг байгаа.

Тэрний дараа санал хураалт явагдах учраас гишүүд танхимдаа орж ирээрэй. Сая Шижир гишүүн үг хэлчхэв үү? Одоо үг хэлэх, асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо үг хэлнэ. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн үг хэлнэ.

Х.Ганхуяг: ХХОАТ-ыг бууруулах гэдэг дээр би яг 100 хувь дэмжиж байгаа юм. Яах вэ энэ дээр ганц, хоёр техникийн алдаа гэх үү, тэгээд яах вэ одоо үзэл баримтлал ингээд өргөн баригдсан болохоор засахад жоохон хүндрэлтэй юм. Хувь хүн дээр заавал ч үгүй прогрессив байх ёстой байдаг юм. Магадгүй та тэн дээр нэг шатлал хийх ёстой байсан юм шиг байна. Тэд хүртэл хүний орлого дээр нэг хувь, тэрнээс дээших нь хэдэн хувь байдаг юм судалгаагаа хийж байгаад. Тэгэхгүй бол яагаад ХХОАТ прогрессив такс хийдэг вэ гэхээр энэ чинь бид нөгөө аж ахуй эрхэлж байгаа ААН-үүд хэлбэр лүүгээ энэ чинь яг нөгөө улс орон бол тэр ААН тал руугаа нь илүү дэмжих явах ёстой байдаг юм л даа. Тэгж байж нөгөө хүний нөөцийн бодлого ч гэдэг юм уу, нэгдсэн байдлаар бизнес дэмжих ийм боломжууд нь ААН хэлбэр дээрээ илүү байх ёстой байдаг юм. Тэгэхгүй бол одоо яг энэ хувиараа нэг хувиараа иргэн гээд явчихаар компани хэлбэрээр бизнес үйл ажиллагаа явуулах тэр идэвх санаачилга нь буурч байдаг байхгүй юу.

Тийм учраас хувь хүн дээр чинь ингээд прогрессив такс гэж оруулж ирж байж тэр юмаа ингэж хааж өгдөг юм. Тэгээд аж ахуйн та хэлбэрээр явбал нөгөө тэр чинь ажлын байр бий болгодог, үйлдвэр бий болгодог тэр утгаар нь энийг ингэж явдаг байхгүй юу. ААН дээр бол одоо яг таных шиг ингээд флат нэг хувийн нэг шатлалын такс тавивал зөв гэж үздэг. Яагаад гэхээр нөгөө олон шатлалтай байхаар одоо манайх чинь олон 3 шатлалтай болох гээд байгаа шүү дээ. Олон шатлалтай байхаар татвараас зугтаах гээд ингээд улам жижгэрээд явчихдаг.

НӨАТ-ын босгыг ингээд 400, 500 сая болгохоор бас ялгаа байхгүй татвараас зугтаах гээд компаниуд жижгэрээд явчихдаг. Яг өнөөдрийн манай татварын энэ бодлогын гол алдаа бол тэр болчхоод байгаа юм. Иргэн дээр болж өгвөл уг нь та нэг хувиа яадаг юм 2 сая төгрөгийн хүртэл орлоготой, дундаж цалин 2 сая 800 статистикаар бол 2 сая 500-аас 800 хавьцаа байх гээд байна шүү дээ, тэр хүртэл нь магадгүй нэг хувь гээд, тэрнээс дээшхийг нь 10, 15 ч гэдэг юм уу ингээд шатлалтай болгочихсон бол сая аль түрүүний гишүүдийн яриад байгаа нөгөө өндөр орлоготой иргэдийг татвараас зайлсхийх боломж, тэгээд дээрээс нь ААН хэлбэр лүүгээ шилжихгүй болчхоод байгаа юм л даа. Тэгэхээр яах вэ гэхээр хүн болгон хувь хүн нэр дээрээ бизнес хийдэг болоод эхэлнэ гэсэн үг. Хувь хүн нэр дээрээ яадаг юм нөгөө компани юу гэдэг юм нөгөө үйлдвэр байгуулаад яваад байх хөшүүрэг нь энэ талдаа ингээд буруу юу л бий болчих гээд байгаа юм л даа. Ийм л 1, 2 юу харагдаад байгаа. Тийм болохоор нэг жоохон энэ талын юм бас нэмж оруулж болохоор уг нь оруулчихвал уг нь сайн байна л гэж хэлэх гээд байгаа юм.

Н.Наранбаатар: Пунсалмаа гишүүн үг хэлнэ.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Хүн амын орлогын албан татварыг нэг хувь болгох энэ саналыг дэмжиж байгаа юм. Өнөөдөр ААН болохлоор хүн амын орлогын албан татварыг 10, 15, 20 хувиар төлж байгаа. Хувиараа иргэд төлбөл нэг хувиар төлөх боломж байгаа. Тэгэхлээр энэчээнээс юу харагдаж байна вэ гэхлээр ерөөсөө ААН компаниудад татвар төлөөд ажиллаж байгаа хүмүүс нь торгууль төлж байгаа юм шиг татвар төлөөд байгаа байхгүй юу. Ялгаатай байна гэсэн үг. Энэчээнээс болохлоор ерөөсөө юу харагдаж байна вэ гэхлээр энэ нэг хувийг бүх

хүн амын орлогын албан татварыг нэг хувь болгочихоор зэрэг төсөв дээр 2,7 их наядын орон зай үүснэ, тэр хэмжээгээрээ орлого тасралт бий болно гээд байгаа юм. Энийг бид шийдэхийн тулд 1 хувь, 10 хувь, 15 хувь, 20 хувиар нь сонголттой болгож болно шүү дээ. Тэгээд өндөр татвар төлсөн хүмүүст нь эргүүлээд буцаалт өгдөг, татвар ер нь яахлаараа дандаа татвар хураалт талаасаа хараад байдаг юм бэ? Иргэдээ дэмжих илүү дэмжлэгийн хөшүүргийн бодлого хэрэглэх хэрэгтэй байна.

Эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй бид хамт очиж уулзсан шүү дээ. Та мэдэж байгаа. Энэ Эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэг юу гэж зөвлөсөн гэхлээр ерөөсөө өндөр татвар төлж байгаа хүмүүст нь эргүүлээд дэмжлэг. Хүүхдийн сургалтын төлбөр, байр орон сууцны хөнгөлөлт, эрүүл мэндийн хөнгөлөлт энэ болгон дээр нь эргүүлээд татвараас тэр өндөр татвар төлсөн хүмүүст нь буцаан олголт өгдөг ийм юм байвал иргэд чинь маш баяр баясгалантайгаар татвараа төлдөг болно. Эргүүлээд энэ татвар төлсөн хүмүүсээ нийгэм нь хамгаалдаг энэ тогтолцоо руу орж ирмээр байгаа юм. Тэгээд өндөр татвар төлсөн хүмүүст нь өндөр буцаалттай, бага татвар төлсөн хүмүүст нь буцаалт байхгүй. Ийм сонголттой болчихвол энэ хүн амын орлогын албан татвар маш сайн ажиллах боломжтой гэж үзэж байгаа юм. Тэгэхлээр цаашид энэ хууль ингээд үргэлжлээд ингээд хэлэлцвэл энэ дээр зарчмын зөрүүтэй саналаар ийм сонголтыг бий болгох хэрэгтэй гэж би энэ ажлын албанд санал болгож байгаа юм шүү. Ингээд нэг хувь болгохыг дэмжиж байгаа.

Н.Наранбаатар: Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд ямар ч байсан маш их эр зориг гаргаад ХХОАТ-ыг нэг хувь болгож бууруулъя гээд АН-ын болон энэ Улсын Их Хурлын 126 гишүүнээ манлайлаад энэ хуулийг өргөн барьсан Баярмаа гишүүнд талархал илэрхийлье. Энийг дэмжиж гарын үсэг зурсан. Учир юу вэ гэхээр одоо ерөөсөө энэ инфляц, төгрөгийн үнийн уналттай холбогдуулаад иргэдийгээ боддог төрийн байгууллага нэг ч байхаа больсон. ЗГ бол ерөөсөө яаж иргэдээ эсвэл бизнесийнхнээс 5, 10 цаасыг нь татвар нэрээр хулгай хийж дээрэмдэж аваад, улаан намын цагаан байрныхан тансаглах уу гэдгээ л боддог болсон. Гарц шийдэл гээд хайгаад байгаа юм. Тэгээд одоо энэ ХХОАТ-ын орлогоор цугларч байгаа 2.6, 7 их наяд төгрөгийг хаанаасаа цуглуулж олж ирэх юм бэ, аймгуудад энэ татвараар чинь бид татаасыг нь өгч амьдруулж байгаа гээд байгаа.

Татвар бол татвар. Улсын төсвийн нэг тогоо руу ороод тэнчээнээсээ яаж зарцуулалт хийх нь Сангийн яам, Ерөнхий сайдын өөрсдийнх нь менежментийн асуудал. Жишээлэхэд энэ Төрийн банк гээд нэг хариуцлагагүй банк байгаа юм. Уг нь Занданшатар Ерөнхий сайд байхдаа хэдэн байгууллагыг хувьчилъя гээд тэрэн дотор Төрийн банк ороод ирчихсэн явж байсан юм. Тэгсэн ЗГ одоо энэ саналаасаа буцаж байгаа юм шиг байгаа юм. Цагаан намын энэ Улаан намын Цагаан байрны нэг даргынх нь үеэл тэнчээ дарга. Жилд 400 орчим сая төгрөгийн цалин авдаг. Тэгээд тэр цалинг чинь тооцоод үзэхэд 3 жил ажиллахад л тэнчээнээс нэг дарга зүгээр цалингаараа тэрбумтан болоод үзүүлчхэж байгаа юм. Нэг даргынх нь жишээ. Тэгээд тэнчээ чинь маш олон дарга байгаа.

Дахиад дээрээс нь энэ Төрийн банкиг бид хувьчлаад явуулчихвал нэг жил зөвхөн нэг удаа энэ иргэдийнхээ нуруун дээр ирээд байгаа энэ татварын ачааллаас нэг удаа хөнгөлөөд өгье гэдэг ийм зарчмын санал л гаргаж байгаа юм. Урсгал зардал чинь энэ төсөв өөрөө тэлээд, урсгал зардал чинь нэмэгдэж явсаар байгаад

сүүлийн 8 жилийн дотор төсөв 2-оос 3 дахин өсчөөд байгаа энэ зардлуудаасаа бид хэмнэе гэвэл юу 2,6 байтугай мөнгө хэмнэх боломжтой. Тэгэхээр энэ хуулийн төслийг зөв талаас нь хараад, энэ Баярмаа гишүүний өргөн барьсан ХХОАТ-ыг нэг хувь болгож, иргэдийн гар дээр мөнгийг нь үлдээх, дотоодын зах зээлд эргэлдэх мөнгийг үлдээх энэ хуулийн төслийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа юм.

Н.Наранбаатар: Одоо 1 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явах учраас Төсвийн байнгын хорооны гишүүд Сүхбаатар танхимд орж ирээрэй. Ганбаатар гишүүн үг хэлнэ.

А.Ганбаатар: Би энэ хорооны гишүүн биш. Гэхдээ Баярмаа гишүүний энэ өргөн барьж байгаа хуулийн төслийг дэмжиж гарын үсэг зурсан юм байгаа юм. Бүх хууль өргөн барих процедур бол явдгаараа явж байгаа. Би тэгээд энэ талаар үг хэлмээргүй байна. Зүгээр болсон явдлыг эргээд харвал ХХОАТ өндөр байгаа нь харагдаж байгаа юм л даа. 10 хувь өндөр байна, нэг хувь болговол яасан юм бэ гэдэг саналыг d.petition дээр 100 мянган хүн, дахиад хэрвээ хугацаа байсан бол хэдэн 100 мянга ч болох байсан юм. Ингэхээр тэр хувь иргэдийн чинь орлого бага байна гэдэг нь харагдаад байгаа юм. Тэгээд үүнийг нь дэмжээд явсан гишүүн маань өнөөдөр хэтрүүлж хэлбэл шүүх хурлаар яривал нэг ийм хариуцагч юм шиг 2,7 их наядын гар нүх гарчихсан чинь тэрийг нь Баярмаа хаанаас ч юм олж нөхөж таглах гээд байгаа ч юм шиг, ингээд 2 тоо мөргүүлэх гээд байгаа юм шиг ийм дүр зураг харагдаад байгаа байхгүй юу.

Энэ бол ЗГ-ын татварын бодлого шүү дээ. Энэ өөрөө улс төрийн шийдвэр байхгүй юу. Тэгээд ингээд гишүүдийн авч явж байгаа хуулийн төслийг ЗГ нь дундаас нь булаагаад авчихдаг. Тэгээд иргэдийн хүсэл цаана нь байгааг ерөөсөө эс тооцоод, тэгээд дунд нь замхруулаад хаячхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр манай Төсвийн байнгын хорооны гишүүд энэ хуулийн төслийг нь зүгээр дэмжиж өгөөд л Их Хурал дээрээ хагалуулчих хэрэгтэй. Тэр хооронд иргэд ард иргэдийнхээ хүслийг санал асуулгаар, тэр сошиал медиагаараа сайн харах хэрэгтэй. Нэг ийм дүр зураг харагдаад байна. Тэгэхээр энэ бол үндсэндээ бараг хуулиараа явбал, дүрмээрээ явбал тэр 2,7 их наядыг мөргүүлэх тухай маргаан болоод л дуусна. Зөвхөн улс төрийн шийдвэр цаана нь гаргах үүднээсээ ЗГ тэр янз бүрийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж болно шүү дээ татварын янз бүрийн хуульдаа.

Эцэст нь хэлэхэд энэ бол улс төрийн хүсэл цаана нь байх ёстой. Хэрвээ улс төрийн хүсэл байхгүй бол энэ унаж таарна. Тэгээд АН-ын гишүүд ард түмнийхээ хүслийг дэмжээд ийм хуулийн төсөл авч орж ирэхээр янз бүрийн байдлаар ингээд техникийн асуудлууд ярьдгаа болих хэрэгтэй байна. Ингээд гарын үсэг зурсан гишүүний хувьд Баярмаа гишүүний оруулж ирж байгаа энэ төслийг Байнгын хороогоор дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Н.Наранбаатар: Гишүүд танхимд орж ирээрэй. Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд танхимд орж ирээрэй. Одоо энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Батболд гишүүн ороогүй байна. 9 хүн гишүүн орсон байна. ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор, Батболд гишүүн ороогүй байгаа юм уу?

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн

томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 47,1 хувиар дэмжигдсэнгүй. Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Баярмаа гишүүн болох билүү? Манай Байнгын хороо биш гэж байна. Ганхуяг гишүүн танилцуулна. ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хоёр. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Байгаа, одоо Пунсалмаа гишүүний өргөн барьсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батболдын Мөнхтөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга, Чадраабалын Сугармаа Зам, тээврийн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Далхаагийн Оюунболд Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Эрдэнэбаярын Балт Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга, Занд-Очирын Энхжаргал Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий менежер, Ганхуягийн Мөнхболд Барилгын хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламжийн зураг төсөл, магадлал, зохион байгуулах хэлтсийн дарга, Банзаарайгийн Нэргүй Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Дармаагийн Амарбаясгалан Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн зөвлөх. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Пунсалмаа гишүүний тогтоолын төсөл. Асуулт, одоо асуулт явна. Дараа нь санал хураалттай. Асуулт байхгүй байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүд анхааралтай байгаарай. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Гишүүд анхааралтай байгаарай, санал хураалтдаа бэлтгэе. Энэ дээр бол би дэмжинэ. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Төсвийн байнгын хорооны гишүүд танхимдаа орж ирээрэй, дэмжинэ. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Тогтоолын төслийн нэрийн “хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж өөрчлөн, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт

шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 52,9 хувиар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “хугацаандаа” гэсний өмнө “эсхүл бусад шалтгаанаар” гэж нэмж, “тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 52,9 хувиар дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “2026 оны 07 сарын 01-ний өдрийн” гэснийг “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 52,9 хувиар дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Энэ тогтоолын 1.1 дэх заалтад заасан тайланд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх, эсхүл хууль зүйн тодорхой үндэслэлтэйгээр цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх эсэх саналаа энэ тогтоолын 1.1-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 52,9 хувиар дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 1.3 дахь дэд заалтыг хасах. Санал хураалт. 52,9 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1.4, 1.5 дахь дэд заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/Улсын Их Хурлаар жилийн төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн бүх шатанд Төсвийн тухай хуулийн 29¹.4-т заасан цахим систем дэх мэдээллээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг Улсын Их Хурлын гишүүд нээлттэй харах боломжийг бүрдүүлэх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 52,9 хувиар дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 2, 3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн 4 дэх заалтын дугаарыг “3” гэж өөрчлөх.

“2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Наранбаатар/-нд даалгасугай.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 47,1 хувь, Ганхуяг гишүүн горимын санал гаргана. Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Байнгын хороон даргаа энэ 7 дугаар санал хураалт дээр миний энэ санал хураах төхөөрөмж ажилласангүй. Дахиад санал хураалт явуулж өгнө үү.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүний гаргасан горимын саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар дэмжигдсэн тул 7

дугаар саналаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 1.1 дэх заалтын “зогссон” гэсний дараа “, анхны төсөвт өртөг нь 50-аас дээш хувиар нэмэгдсэн,” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл. Санал хураалт. Зөв, зөв, 47,1 хувиар санал дэмжигдсэнгүй. 9, үгүй энэ дэмжихгүй.

9.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “төсвийн хуульд тусгаж” гэсний өмнө хэдэн оноос хойших төслүүд хамааралтай байх талаар эхэлсэн хугацааны хязгаарлалт тавих гэж байгаа юм. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл. Санал хураалт. Рэгдэл гишүүн саналаа тайлбарлая.

Д.Рэгдэл: 8 дахь санал уначихсан юм чинь 9 дэх бол утгагүй юм л даа. Татаад авчихъя.

Н.Наранбаатар: Хэдийг татаж авсан бэ 9 үү, 8 уу? 9-ийг татаж авсан учраас санал хураах шаардлага байхгүй.

10.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “хуульд тусгаж” гэснийг “хуулиар баталж” гэж, “анх батлагдсан” гэснийг “анхны” гэж, “буй ачаалал, дарамт” гэснийг “байгаа нөлөөлөл” гэж, “бүрээр тус бүр үнэлж” гэснийг “нэг бүрээр судалж” гэж тус тус өөрчилж, мөн дэд заалтын “заалтын талаар судалж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар. Санал хураалт. 58.8 хувиар дэмжигдлээ. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн унших вэ? Энхтүвшин гишүүн уншина. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

13.16 цаг

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА